

**Улаанбаатар: ӨНӨӨДӨР**

Өдөр -9  
Шөнө -23

**УЛС ТӨР**

**ӨНӨӨДРӨӨС ЭХЛЭН ЭМНЭЛГҮҮД СОГТУУРСАН ИРГЭДИЙГ ХҮЛЭЭН АВАХГҮЙ**

II нүүрт

**ДЭЛХИЙ**

**Д.ТРАМП СИ ЗИНЬПИНД ЗАХИДАЛ БИЧЖЭЭ**

IV нүүрт

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

**Шатахууны үнийн дарамт ЭХЭЛЛЭЭ**

Н.ПУНЦАГБОЛД

Эрх баригчид улс оронд тулгараад байгаа олон асуудлыг шийдэх гэж хэрэндээ л ажиллаж байх шиг байна. Эдийн засгийн хямрал, гадаад ор гээд л асуудал юу мундах билээ. Гэтэл ядахад яр гэгчээр шатахууны үнэ бас өнөөх хэдийн нуруун дээр дарамт үүсгэж эхэллээ. Өнөөх хэдээр тогтохгүй одоо бүр ард иргэдийг хүртэл дарамталж байна. Уг нь Засгийн газар саяхан л автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг бууруулсан. Нэг хэсэг дэлхийн зах зээл нефтийн бүтээгдэхүүний үнэ буурсан. Тэгвэл сүүлийн үед буцаад бага сага өсөөд байгаа. Нөгөө талаар төгрөг цаас болж, ам.долларын ханш хэтэрхий их өссөн.

Үргэлжлэл нь III нүүрт



## ХЭН, ЮУ ХЭЛЭВ

Н.ПУНЦАГБОЛД

**С.Эрдэнэ: 350 тэрбум төгрөгийн төлбөрийг Монголын тал төлөх үүрэгтэй болох нь**

“Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувь сүүлийн үед улстөрчдийн ярианы сэдэв болчихоод байгаа билээ. Тэгвэл УИХ дахь АН-ын Бүлгийн дарга С.Эрдэнэ “Эрдэнэт”-ийн асуудлаар байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр “Эрдэнэтийн 49 хувь Монголын талд орж ирсэн нь ямар ч маргаангүй хамгийн зөв хувилбар. Харин хууль бус байсан эсэхийг холбогдох хууль, хяналтын байгууллагууд шалгах ёстой. Бид өнөөдөр Ц.Нямдорж гишүүнийг нэг зүйл дээр гайхаад байна. Ц.Нямдорж гишүүн өмнө нь УИХ дээр ямар нэг асуудал ярихаар УИХ бол мөрдөн шалгах газар, шүүх биш. Холбогдох байгууллага нь шалгах ёстой гэдэг байр суурийг үргэлж давтаж хэлдэг байсан. Гэвч өөрөө УИХ-ыг шүүх байгууллага, мөрдөн шалгах газар шиг болгож байгаад нь гайхаж байна. Энэ 49 хувиас гадна Эрдэнэтийн 51 хувь маш ноцтой асуудлыг дагуулахаар нөхцөл байдал үүсээд байна. Английн Арбитрын шүүхээс “Стандарт” банкны барьцаанд тавьсан гэх Эрдэнэтийн 51 хувьтай холбоотой шийдвэр гарсан тухай урьдчилсан мэдээлэл ирсэн байгаа. 140 сая ам.доллар буюу 350 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төлбөрийг Монголын тал төлөх үүрэгтэй болох нь. Олон улсын Арбитрын шүүхээр батлагдаад гараад ирвэл аль ч улс дагаж, мөрдөх үүрэг хүлээнэ. Үүнээс болж манай улсын хувьд нэлээд ноцтой байдал үүсэх нь гэдэг асуудал яригдаж байна. Өнөөдөр 51 хувь маань Монголд байна уу. Үнэхээр төрд бий гэж яриад байгаа боловч төр гэдэг нэрийн цаана өмчийг эзэнгүйдүүлдэг, дуртай хүндээ аваачиж өгч барьцаанд тавьдаг ийм л байдал харагдаж байна” хэмээн ярьжээ.

Үргэлжлэл нь III нүүрт

**ОНЦЛОХ МЭДЭЭ**

**Эрх баригчдын шөнийн хуйвалдаан**

Г.ГЭРЭЛ

Хууль зүйн байнгын хороо энэ сарын 08-ны хуралдаанаараа “Эрдэнэт”-ийн 49 хувийг төрд шилжүүлэх санал дүгнэлтийг хэлэлцэж, өчигдөр чуулганы хуралдаанд оруулах ёстой байсан. Гэвч ажлын цаг дуустал уг хурал зарлагдаагүй. Үүнийг Байнгын хорооны дарга Ш.Раднаасэд тайлбарлахдаа “Маргааш энэ асуудлыг хэлэлцэхээр болсон” гэж мэдээлэл авахыг хүссэн хэвлэлийнхнийг тараасан юм.

Тэгвэл МАН-ын бүлэг шөнө дөлөөр хуралдаж, ажлын бус цагаар Эрдэнэт үйлдвэрийг 100 хувь төрийн мэдэлд авах шийдвэр гаргажээ. Үнэхээр эх орныхоо хөгжлийн төлөө санаа зовниж, унтах нойр идэх хоолоо хугаслан хуралдсан бол олонхио сайшаалтай.

Харамсалтай нь, ийнхүү харуй бүрийгээр хуйвалдаан зохион байгуулсны цаад шалтгаан нь данч ноцтой аж. Тодруулбал, МАН-ын дарга М.Энхболд Хятадаас зээл авахын тулд нэгд, Эрдэнэтийг 100 хувь өөрийн мэдэлд оруулах, хоёрт, Тавантолгойн 49 хувийг Хятадын төрийн компанид нь шилжүүлэх гэсэн хоёр асуудлыг шийдвэрлэсэн байх амлалт авсан тухайгаа бүлгийн хурлын үеэр мэдээлсэн байна.

Ийнхүү олонхиороо кнопдож, бүлгийн шийдвэрээ дэмжүүлснээр Монгол Улсын төр Хятадаас шууд хамааралтай болох эхний сууриа баталж өгнө. Энэ нь МАН-ын хувьд урд хөршийн өмнө гүйцэтгэлээ сайн хийсэн гавьяа боловч, монголчуудын дунд эх орноо зарсан урвагчид гэх хар нэр зүүж, харин удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуулиар АН-д нам цохиулах том алдаа болох биз ээ.

**ДЭЛХИЙ**

## Пак Гын Хегийн нам "Зүсээ хувилгажээ"

Б.ДАВАА



Найзынхаа балгаар Ерөнхийлөгчийн зөвлөн суудлаасаа буухад хүрсэн БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хегийн “Сэнүри” нам тус улсад үүссэн улстөрийн дуулиан шуугианы дараа нэрээ шинэчилжээ. Тэд энэ удаа “Сэнүри” нэрээ “Эрх чөлөөт Солонгос” хэмээн өөрчилсөн байна. Тус намын хэвлэлийн төлөөлөгч өчигдөр шинэ нэрийн талаархи мэдээллийг олон нийтэд цагжээ.

Үргэлжлэл нь IV нүүрт

**ЧУУЛГАНЫ ТАНХИМААС**

## Өнөөдрөөс эхлэн эмнэлгүүд согтуурсан иргэдийг хүлээн авахгүй

Ж.ОТГОН

УИХ-ын чуулганы хуралдаан 51.3 хувийн ирцтэйгээр эхэлсэн юм. Хуралдааны эхэнд Цагдаагийн албаны тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй Цагдаагийн албаны тухай хуульд алба хаагчийн эрх зүйн байдал болон цагдаагийн байгууллагын зарим үйл ажиллагаатай холбоотой харилцааг тусдаа хуулиар зохицуулахаар тусгасан. Гэвч

дээрх зохицуулалтуудыг агуулсан тусгайлан хууль одоог хүртэл батлагдаагүйн улмаас цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаа, хөдөлмөрийн дотоод харилцаа зэрэг олон зохицуулалтууд нь Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг журмаар зохицуулагдаж байгаа юм. Мөн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхтэй холбоотой харилцааг зөвхөн журмаар зохицуулж иржээ.

Үргэлжлэл нь II нүүрт

### Таны гэр бүлийн хамгийн зөв сонголт

#### “ЦАГААН САРЫН”

Хямдралтай, Урамшуулалт худалдаа

30000 төгрөгнөөс дээш үнэгүй хүргэлттэй

~~6900₮~~

6200₮

**Since 1899**

Хүргэлтийн утас: 75755550

И-март, Home Plaza, 3-гал худалдааны төв В1, Шарга төв /3-р хороолол/, АСА циркийн баруун урд Эмөн 18/3 байр

ХААН банк			Худалгаа хөгжлийн банк		
	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2474.00	2488.00	ФУНТ	3047.00	3151.00
ЕВРО	2612.00	2682.00	РУБЛЬ	40.10	43.60
ИЕН	21.87	22.25	ЮАНЬ	360.00	364.90
			АМ.ДОЛЛАР	2480.00	2490.00
			ЕВРО	2621.00	2701.00
			РУБЛЬ	40.64	44.23
			ЮАНЬ	360.00	365.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

**Унгарын тэтгэлгээр 200 иргэнийг суралцуулна гэв**

Засгийн газрын гишүүн, БСШУС-ын сайд Ж.Батсуурь, Унгар улсаас Монголд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мадари Акош нар “Хамтын ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах баримт бичиг”-т өчигдөр гарын үсэг зурлаа. Монгол Улсын БСШУСЯ, Унгар улсын Хүний Нөөцийн яам хоорондын хамтын ажиллагааны энэхүү баримт бичгийг 2015 оны дөрөвдүгээр сарын 15-нд анх үзэгдэж байжээ. Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулснаар Монгол Улсаас Унгар улсын Засгийн газрын тэтгэлгээр 200 хүртэлх монгол иргэнийг суралцуулахаар болж байна. Мөн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Унгарын тал бакалаварт 70 хүүхэд, магистрантурт 75, докторантурт 30 монгол иргэнийг суралцуулахаар төлөвлөж байна. Түүнчлэн 15 Монгол иргэнийг богино хугацааны нэг түвшний сургалтын хөтөлбөрт хамруулна. Унгар улсад хөдөө аж ахуй, нийгмийн ухаан, мэдээлэл зүй, хууль эрх зүй, эдийн засаг, инженер, анагаах ухаан, арга зүй, байгалийн шинжлэх ухаан, соёл урлаг зэрэг мэргэжлээр суралцуулах юм. Хөтөлбөр энэ оны арванхоёрдугаар сарын 31-ний өдөр хүртэл үргэлжлэх юм байна.

# ӨНӨӨДРӨӨС ЭХЛЭН ЭМНЭЛГҮҮД СОГТУУРСАН ИРГЭДИЙГ ХҮЛЭЭН АВАХГҮЙ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Тиймээс хуулийг шинэчлэн боловсруулж, дээрх дутагдалтай заалтуудыг нэмж байгаа юм. Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн С.Чинзориг “Цалин хөлсний талаар Хөдөлмөрийн тухай хуульд заагаад өгчихсөн байхад энэ хуульд цолны цалин гэдэг юм нэмээд оруулаад ирчихсэн байх юм. Цолны цалин, цалин хөлс гэж тусдаа байх шаардлагатай юу” гэдгийг тодрууллаа. Үүний хариуд УИХ-ын гишүүн Ц.Нямдорж “С.Чинзориг гишүүний хэлж байгаа нь зөв. Дараа нь энэ хуульд өөрчлөлт оруулах шаардлага гарвал хасчих байх. Ер нь цагдаа нар бол халуунд халж, хүйтэнд хөрж явдаг. Хамгийн хүнд хүчир алба хашдаг хүмүүс атал 600-700 мянган төгрөг авдаг” гэлээ. Харин УИХ-ын гишүүн Л.Болд “Ц.Нямдорж даргын ярьж байгаатай санал нэг байна. Үнэхээр цагдаагийн албан хаагчийн нийгмийн асуудалд анхаарах ёстой. Хоёрдугаарт, цагдаа хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах эрхийг нь бүрэн хангах хэрэгтэй. Цагдаагийн генерал гэдэг цол олгох хэрэг байна уу” гэв. Асуултын хариуд УИХ-ын гишүүн Ц.Нямдорж “Цагдаагийн генерал цол олгодог 40 гаруй улс орон байдаг. Бие даасан улс хэдэн генералтай байхад буруудаад байх юу байх вэ дээ. Төртэй улсад байдаг л асуудал” хэмээн тайлбарлав.

## Цагдаа хүчрэхгүй болсон үед дотоодын цэрэг дэмжлэг үзүүлнэ

Үүний дараа Засгийн газраас өргөн мэдүүлсэн Дотоодын

цэргийн тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Хуулийн төсөлд Дотоодын цэргийг сэргээн байгуулах асуудлыг тусгасан юм. Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн Л.Болд, “Чуулганы өнөөдрийн хуралдааны хуваарьт Дотоодын цэргийн тухай хууль ороогүй байсан. Дотоодын цэрэг байгуулах асуудал дээр УИХ нэлээд нухацтай хандах хэрэгтэй. Дотоодын цэрэг гамшгийн үед ажиллана гэж хуульчилсан байна. Онцгой байдлын байгууллага гэж байгаа шүү дээ” гэв. Үүнд нь УИХ-ын гишүүн Ц.Нямдорж, “Дотоодын цэрэг 1922 онд байгуулагдаж, монгол төрийн төлөө ажиллаж байсныг 2014 онд татан буулгасан. Татан буулгасан нь буруу боллоо гээд Д.Дорлигжавын үед хууль өргөн барьж байсан. Үүнийг нь одоогийн Хууль зүйн яамныхан дахин өргөн бариад хэлэлцээд явж байна. Дотоодын цэрэг хамгаалалтын үйл явц хариуцна. Гамшиг гарсан үед буюу цагдаа хүчрэхгүй болсон үед дотоодын цэрэг дэмжлэг үзүүлж ажиллах юм” гэсэн хариу тайлбар хийв. Ийнхүү гишүүд хэлэлцэж үйл асуудлаар асуулт асуусаны дараа байнгын хорооны түвшинд гарсан 38 зарчмын зөрүүтэй санал тус бүр дээр санал хураалт явуулав. Ингээд хуулийг бүхэлд дэмжих эсэх дээр санал хураалт явуулахад олонх дэмжлээ.

## Хөгжлийн банкны хуулиар МАН-ын бүлэг завсарлага авлаа

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцэж, батлав. Хуулийн төслийг хэлэлцэх үеэр асуух асуулттай гишүүн байгаагүй тул холбогдох бусад хуулийн төслөөр санал хураалт явуулаад, бүхэлд нь баталсан юм. Үүний дараа Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийв. Энэ үеэр мөн л асуух асуулттай гишүүн байсангүй.

Хуулийн төслийг УИХ-ын гишүүн Н.Энхболд танилцуулаад, санал хураалт явуулж батлав. Дараагийн асуудал нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлэг байлаа. Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн “Өнөөдөр энэ хуулийг хэлэлцэх гэхээр Дэгийн тухай хууль талаасаа болохгүй болчихсон асуудал бий. Төсвийн байнгын хороон дээр хуулийн зөрчилтэй асуудлыг хэлэлцээгүй зүйл бий. Яг энэ байдлаар явна гэхээр хуулийн зөрчилгүй арилгагүй хэлэлцсэн болчихно. Гэхдээ хуулийг нь баталж гаргахгүй бол одоо чуулган завсарлах гэж байна. Хавар гэхэд бизнес цикл эхэлнэ. Тиймээс энэ баасан гараг гэхэд баталж гаргах нь зүйтэй” гэлээ. Тиймээс УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар, Д.Тэрбишдагва нар маргааш / өнөөдөр/ хэлэлцэх нь зүйтэй гэдэг байр сууриа илэрхийлсэн. Үүнтэй холбоотойгоор УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа нэг хоногийн завсарлага авах хүсэлт гаргав. Ингээд Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр УИХ дахь МАН-ын бүлэгт нэг хоногийн завсарлага өгөв.

## Хэнтий хан уулын Бурхан халдун уул хэмээн нэрлэв

УИХ-ын чуулганы хуралдаанаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Хэнтий Хан уулын нэрийг Бурхан Халдун уул гэж өөрчлөх тухай” УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийв. Монгол Улсын Ерөнхийлөгч үндэстний өв соёлыг хадгалж хамгаалах, сурталчлан таниулах үүднээс 2010 онд Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн газар нутгийн байгалийн болон соёлын хосгүй гайхамшигт үнэ цэнийг тодорхойлж Дэлхийн өвд бүртгүүлэх тухай зарлиг гаргасан. Уг зарлигийг хэрэгжүүлж, холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэснээр ЮНЕСКО-

гийн Дэлхийн өвийн хорооны 39 дүгээр чуулганы 2015 оны долдугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар “Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг гэсэн өвийг хэлэлцэн баталж, Дэлхийн соёлын өвд бүртгэсэн. Гэтэл нэр дэвшүүлэх материал боловсруулах бэлтгэл ажлын явцад Бурхан Халдун уулын нэр нь Монголын газрын зурагт тэмдэглэгдээгүй байжээ. Иймд Монгол Улс энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болсон учир Хэнтийн нурууны далайн төвшнөөс дээш 2361.5 метрт орших Хэнтийн Хаан уул гэсэн тоот өндөрлөгийн албан ёсны нэрийг Бурхан Халдун уул болгон өөрчлөх нь зүйтэй гэж үзсэн юм. Хэлэлцүүлгийн шатанд олонх дэмжсэн тул хуулийн төсөл батлагдлаа. Мөн үеэр УИХ-ын дарга М.Энхболд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо ойрын хугацаанд тус хуулийн талаар олон нийтэд зөв зүйтэй мэдээлэл өгөх нь зүйтэй гэсэн үүрэг өглөө.

## Д.Сарангэрэл, Ц.Гарамжав, Х.Нямбаатар нар сэтгүүл зүй, сошиал хоёроо ялгах хэрэгтэй

УИХ-ын үдээс хойших хуралдаанаар Сogтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталлаа. Цагдаагийн алба хаагч согтуу иргэдийг шууд эмнэлэгт авчирч байгаа нь эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг байна. Согтуугаар эмнэлэгт хүргэгдэн ирсэн иргэд эмч нарт үзүүлэхгүй агсам тавих, зодох, зүй бусаар авирлах, эмнэлгийн багаж төхөөрөмж, эд хогшлын эвдэх, эмнэлгийн орчныг бохирдуулах, эмч,

ажилчдыг заналхийлэх, зодож гэмтээн эрүүл мэндээр хохироогоод зогсохгүй бусад эмчлүүлэгчдийн амгалан тайван байдлыг алдагдуулдаг аж. Агсам согтуу тавьсан этгээдийн эсрэг хүч хэрэглэх боломж, өөрсдийгөө хамгаалах арга хэрэгсэл, эрх зүйн орчин эмч, эмнэлгийн ажилтнуудад байдаггүй тул өөрсдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсоор байгаа юм. Тиймээс эрүүлжүүлэх асуудлыг цагдаагийн байгууллага шилжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан байна. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүн байсангүй. Ийнхүү санал хураалт явуулахад гишүүдийн 71.4 хувь дэмжиж, батлав. Хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөх юм.

Үүний дараа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл “Байнгын хороон дээр УИХ-ын гишүүн Ц.Гарамжав, Х.Нямбаатар нар хэвлэлийг нэлээд буруутгасан байна. Манай улс төрчид сэтгүүл зүй, сошиал хоёроо ялгах хэрэгтэй байна. Үүнд маш том андуурал явж байна. Сошиалд яригдсан зүйлийг сэтгүүл зүй гэж ойлгоод байна. Аливаа асуудлыг нийтэд нязлааж ойлгох буруу. Энэ байдлаар МАН-ын 65 гишүүн хэвлэлийн эсрэг байгаа мэт харгадуулж байна” хэмээн бухимдав. Үүний дараа УИХ-ын хаагч согтуу иргэдийг шууд эмнэлэгт авчирч байгаа нь эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг байна. Согтуугаар эмнэлэгт хүргэгдэн ирсэн иргэд эмч нарт үзүүлэхгүй агсам тавих, зодох, зүй бусаар авирлах, эмнэлгийн багаж төхөөрөмж, эд хогшлын эвдэх, эмнэлгийн орчныг бохирдуулах, эмч,

# Ж.Эрдэнэбат: Манай улс 60 гаруй сая малтай ч гадаадаас хуурай сүү импортоор авдаг...

Б.АЛТАНБАГАНА

Засгийн газар хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр, боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эдээр тогтвортой хангах зорилт тавьж, “Мах сүүний анхдугаар аян”-ыг орон даяар өрнүүлж эхэлсэн. Энэ хүрээнд хуурай сүүний тоног төхөөрөмжийг танилцуулах эхний ээлжийн сургалт, хэлэлцүүлэг ХХААХУ-ийн яамны хурлын танхимд боллоо. Сургалт, хэлэлцүүлэгт Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, ХХААХУ-ийн сайд П.Сэргэлэн, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, албаны болон хөдөө орон нутгаас ирсэн сүүний үйлдвэрлэл, фермерийн аж ахуй эрхлэгчид,



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

хоршоологчид оролцлоо. Үйл ажиллагааг нээж ХХААХУ-ийн сайд П.Сэргэлэн үг хэллээ. Тэрбээр “Засгийн газрын 2016-2020 оны үйл

ажиллагааны хөтөлбөрт “Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг

бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулах зорилгыг дэвшүүлсэн. Манай яамнаас Мах, сүүний анхдугаар аяны өргөн хүрээнд авч үзэж, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй, гэжээлийн тариаланг дэмжих, мах, сүү бэлтгэлийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, мах, сүүний боловсруулах салбарыг хөгжүүлэх, дотоодын хэрэглээ болон экспортыг нэмэгдүүлэх гэсэн чиглэлүүдээр зохион байгуулахаар ажиллаж байна” гэдгийг онцоллоо. “Мах, сүүний анхдугаар аян”-ы хүрээнд олон зорилтот арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсний нэг нь энэхүү сургалт, хэлэлцүүлэг болж байгаа

ажээ. Энэ үеэр Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Манай улс 60 гаруй сая малтай ч гадаадаас хуурай сүү импортоор авдаг. Энэ төхөөрөмжийг орон нутагт ажиллуулснаар байнгын худалдан авагч, хэрэглэгч бий болно. Энэ хэрээр зах зээл дээрх үнэ тогтворжиж, малчин айл өрх ч өдөр тутмын орлоготой байх боломж бүрдэнэ. Цаашид хуурай сүүнийхээ хэрэгцээг дотооддоо хангах улмаар экспортод гаргах хэмжээнд очих зорилт тавьсан. Монголчууд хийж чаддаг зүйлээ өөрсдөө үйлдвэрлэе, хийсэн бүтээгдэхүүн маань иргэдийн хэрэгцээг хангаж, шаардлагыг хангасан байх ёстой” гэв.

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757


Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



“  
 I ài ài òòî î yǒò ì yǎyè  
 áòèààòàèèàñàí yñáyè  
 ñî ì ááòóèüä çî ðèòéñàí  
 î àèèàî àçé àèòî óóà íü  
 Î ì íáî è Òèñüí í yǒò òçíä,  
 yàèéí çàñààò í°ò°æ áàððàçé  
 òî òèòî è ó÷ðóóèèàààð áàéí à.”

Эдийн засаг  
 Ч.Отгонгүлүү

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Дугаарын 60 мөр

## Шатахууны үнийн дарамт ЭХЭЛЛЭЭ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Энэ шалтгаан нь шатахуун импортлогчид бензинхээ үнийг нэмэх сайхан шалтаг болж өгсөн нь дамжиггүй. Тиймээс ч Засгийн газар шатахууны үнийн өсөлтөөс сэргийлэх үүднээс автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг дахин бууруулсан хэрэг. Өмнө хоёр ч удаа бууруулаад байсан татвараа дахин багасгасан. Гэхдээ бүр үлэмж хэмжээгээр. Тухайлбал, автобензинд ногдуулах онцгой албан татварыг 160 мянган төгрөгөөс 50 мянга болгож, /90-ээс дээш октантайг 160 мянган төгрөгөөс 30 мянга/, дизелийн түлшинд ногдох татвар 180 мянган төгрөг байсныг 70 мянга болгон бууруулж тогтоосон. Үндсэндээ татварыг 3-5 дахин бууруулж байгаа юм. Ингэснээр улсын төсвийн орлого 110 орчим тэрбум төгрөгөөр буурах ч, шатахууны үнийн өсөлтийг саармагжуулах боломжтой гэж холбогдох яам болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын холбоо үзэж байгаагаар ч тухайн үед хэлж байсан. Гэтэл өсөлт саармагжих нь битгий хэл эсрэгээрээ идэвхжиж эхэллээ. Хамгийн түрүүнд “Петровис” компани шатахууныхаа үнийг 100 төгрөгөөр нэмсэн. Одоо бараг бүх шатахуун импортлогчид үнэ дуураа авалцан нэмж байна. Уг нь Засгийн газрын тогтоол гарч байхад хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Лхагва нарт үүрэг болгосон. ШӨХТГ-ынхан шатахууны үнэ нэмэгдэхтэй зэрэгцээд хэвлэлийн хурал хийж, буцааж бууруулах шаардлага хүргэж байгаа тухайгаа хэлсэн. Тогтоолыг хэрэгжүүлэх гэж үзсэн хэрэг. Гэвч тэдний хүч хүрсэнгүй бололтой. Ямар ч байсан шатахууны үнэ буцаад нэмэгдчихлээ. Шатахууны үнэ нэмэгдэж байгаа сургаар борооноор дайрдаг чоно шиг хэсэг бүлэг ч бас байна. Юуны өмнө таксинд явдаг “гар”-ууд үнэ 100 төгрөгөөр нэмээд эхэлчихлээ. Уг нь км-ыг нь 800 төгрөгөөр явдаг байтал 900, цаашлаад 1000 төгрөг нэхээд эхэллээ. Шалтгаан нь шатахууны үнийн өсөлт юм байх. Уг нь өмнө нь шатахууны үнэ 1530 төгрөг байж байгаад буурч, 1480 болсон. Тэгэхэд хэн бараа бүтээгдэхүүний үнийг бууруулсан билээ. Ямар такси компани км тутмынхаа үнийг багасгалаа. “Ёстой тийм юм байхгүй шүү” гэдэг шиг л байсан биз дээ. Гэтэл эргээд хэдэн төгрөг нэмэгдэхтэй зэрэгцээд үнэ өсгөөд эхэллээ. Мэдээж үүнийг хянах систем гэж манайд байхгүй л дээ. Зах зээл л зохицуулах ёстой гээд орхихоос өөр яалтай. Гэхдээ нэгэнт л шатахууны үнэ зохицуулах гэж янз бүрээр оролдож байгаагаас хойно уг нь энэ удаадаа нэмэгдэхгүй байх бүхий л арга хэмжээг авах ёстой байсан юм. Гэвч Засгийн хийсэн ажлыг шатахуун импортлогчид ч тоосонгүй, тогтоолын хэрэгжилтийг хянах ёстой хүмүүс нь ч ажлаа илүү сайн хийж чадсангүй бололтой. Ингээд л ард түмний нуруун дээр илүү их дарамт ирэх нь тодорхой болчихлоо. Уг нь шатахуун импортлогчдын ихэнх нь МАН тодотголтой хүмүүс байдаг санагдах юм. Дээрээс нь энэ намынхан эрх барьж, 65-уулаа саарал ордонд сууж байгаа. Гэтэл шатахууны үнийн асуудлаа бага ч болов тогтоож дийлсэнгүй. Одоо яалтай ч билээ, нуруугаа илүү богтгийгөөд, ачаагаа үүрцгээе дээ.

### ҮЗЭЛ БОДОЛ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Ч.Энхбат: Өнгөрсөн жилүүдэд Хөгжлийн банк улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 3.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон

*/Монгол Улсын Хөгжлийн банкны Тэргүүн дэд захирал/*  
 Сүүлийн үед хамгийн их яригдаж байгаа асуудал бол Хөгжлийн банкны 580 сая ам.долларын өр. Энэ өрийг ирэх гуравдугаар сарын 21-ний дотор төлөх ёстой. Тэгвэл Хөгжлийн банкны Тэргүүн дэд захирал Ч.Энхбат зарим зүйлийг ярьжээ. Тэрбээр “Өнгөрсөн жилүүдэд Хөгжлийн банк улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 3.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон байдаг. Тодруулж хэлбэл, “Энэ өдрүүдэд Засгийн газраас ОУВС-ын “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах асуудлаар гэрээ, хэлэлцээрүүд хийгдэж байна. Өрийн дарамт нэмэгдэж, валютын нөөц багассан ийм эмзэг үед ОУВС-ын “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдаж байж эдийн засгийн хүндрэлээ даван туулна. Энэ байр сууриа би 2014 оноос хойш илэрхийлж байна. Өмнө нь 2008-2009 оны Дэлхийн эдийн засгийн хямралын үед Монгол Улс ОУВС-ын “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдсанаар хүндрэлийг богино хугацаанд гэтэлсэн. Тэр үед иргэд, ААН-үүдэд эдийн засгийн хүндрэл өнөө үетэй харьцуулахад харьцангуй бага мэдрэгдсэн байдаг. Гэтэл ОУВС-тай хэлцэл зайлшгүй хийх ёстой чухал үед Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах замаар УИХ-д Хөгжлийн банкний хамаагүй болгож, Төсвийн тухай хуульд хамааралгүй болгох гээд байна. Улсын төсөвтэй тэнцэх хэмжээний томоохон зарцуулалттай банкны асуудал төсвөөс гарч, УИХ-аас гарсан тохиолдолд ОУВС үүнд сөрөг байр суурь илэрхийлэх нь ч ойлгомжтой. ОУВС-гаас олон төсөвтэй явах ёсгүй, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг УИХ-аас гаргаж, засгийн газар хэрэгжүүлэх ёстой гэж үздэг. Гэтэл ОУВС-д хамрагдах шийдвэрийн өмнө УИХ-ын энэ эрх байхгүй болох хууль эрх зүйн орчин үүсчих гээд байна. Тиймээс ч миний зүгээс үнэхээр ОУВС-гийн “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах гэж байгаа бол харилцан зөвшилцөх ёстой гэсэн байр суурь илэрхийлсэн. Хэрвээ бид ОУВС-тай энэ асуудлаар зөвшилцөхгүйгээр “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах гэрээ байгуулвал уг хуулийг дахин өөрчлөх шаардлага үүснэ. УИХ-ын гишүүд хуулийн төслийг баахан цаг гаргаж суугаад баталчихдаг.

# ХЭН, ЮУ ХЭЛЭВ

санхүүжилтийг хийхгүй болсон хэмээн ярьжээ.

Ч.Хүрэлбаатар: “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдаж байж эдийн засгийн хүндрэлээ даван туулна

*/УИХ-ын гишүүн/*  
 Монгол Улс ОУВС-гаас зээл авахаар хэлэлцээр хийж байгаа билээ. Энэ зээл бүтэх эсэхээс шалтгаалаад эдийн засаг сэргэх үү, үгүй юу гэдэг нь тодорхой болно. Тэгвэл энэ талаар УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ч.Хүрэлбаатар “Энэ өдрүүдэд Засгийн газраас ОУВС-ын “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах асуудлаар гэрээ, хэлэлцээрүүд хийгдэж байна. Өрийн дарамт нэмэгдэж, валютын нөөц багассан ийм эмзэг үед ОУВС-ын “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдаж байж эдийн засгийн хүндрэлээ даван туулна. Энэ байр сууриа би 2014 оноос хойш илэрхийлж байна. Өмнө нь 2008-2009 оны Дэлхийн эдийн засгийн хямралын үед Монгол Улс ОУВС-ын “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдсанаар хүндрэлийг богино хугацаанд гэтэлсэн. Тэр үед иргэд, ААН-үүдэд эдийн засгийн хүндрэл өнөө үетэй харьцуулахад харьцангуй бага мэдрэгдсэн байдаг. Гэтэл ОУВС-тай хэлцэл зайлшгүй хийх ёстой чухал үед Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах замаар УИХ-д Хөгжлийн банкний хамаагүй болгож, Төсвийн тухай хуульд хамааралгүй болгох гээд байна. Улсын төсөвтэй тэнцэх хэмжээний томоохон зарцуулалттай банкны асуудал төсвөөс гарч, УИХ-аас гарсан тохиолдолд ОУВС үүнд сөрөг байр суурь илэрхийлэх нь ч ойлгомжтой. ОУВС-гаас олон төсөвтэй явах ёсгүй, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг УИХ-аас гаргаж, засгийн газар хэрэгжүүлэх ёстой гэж үздэг. Гэтэл ОУВС-д хамрагдах шийдвэрийн өмнө УИХ-ын энэ эрх байхгүй болох хууль эрх зүйн орчин үүсчих гээд байна. Тиймээс ч миний зүгээс үнэхээр ОУВС-гийн “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах гэж байгаа бол харилцан зөвшилцөх ёстой гэсэн байр суурь илэрхийлсэн. Хэрвээ бид ОУВС-тай энэ асуудлаар зөвшилцөхгүйгээр “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах гэрээ байгуулвал уг хуулийг дахин өөрчлөх шаардлага үүснэ. УИХ-ын гишүүд хуулийн төслийг баахан цаг гаргаж суугаад баталчихдаг.

Дараа нь дахин өөрчлөхөөр нэг ажлыг хоёр хийнэ л гэсэн үг. Тэгэхээр бид асуудлаа эхнээс нь нэг мөр шийдээд, нөхцөл байдалтайгаа холбоод явах хэрэгтэй. Би энэ асуудлаар хоёр долоо хоног байр сууриа илэрхийлж, ОУВС-тай гэрээ хэлэлцээ хийж байгаа нөхцөл дотор энэ асуудал багтсан эсэхийг лавлахаар Засгийн газар, Сангийн яаманд албан бичиг хүртэл хүргүүлсэн. Хариу нь ирээгүй л байна” хэмээн ярьжээ.

Ч.Гантулга: Эхлээд яндан нэмэхийг хориглосон журмаа гаргачихлаа, дараа нь бага багаар цөөлнө

*/НИТХ-ын төлөөлөгч/*  
 НИТХ-ын төлөөлөгч Ч.Гантулга нийслэлээс хийж хэрэгжүүлж байгаа ажил, тэр дундаа утааны эсрэг авч хэрэгжүүлж буй

бодлогын талаар ярьжээ. Тэрбээр “Нийгмийг хамарсан том асуудалд бол ул суурьтай хандах ёстой. Богино хугацаандаа ямар ажил хийх юм, үр дүн нь юу байх юм. Урт хугацаандаа бид юу хүлээж байгаа юм, юу үлдэх юм, ийм хоёр чиглэлийг л барьж ажиллах ёстой. Богино хугацаанд хийх ажил гэвэл Улаанбаатар хотыг бүсчилнэ. Жишээ нь, нэгдүгээр бүсэд бол хамгийн гамшгийн хэмжээнд хүрсэн газрыг хамруулж байгаа. Цаашлаад, хоёр, гурав, дөрөвдүгээр бүс гээд хуваах юм. Дөрөвдүгээр бүсэд бол төвийн хэсгийн хороолол багтана. Энэ мэт бүсчилсэн зураглал гарсан байгаа. Бид хурал хийгээд, шийдвэр гаргаад л, бүх янданг байхгүй болгочихно гэж байхгүй. Тухайн иргэн, аж ахуйн нэгжийн эрхийг зөрчиж болохгүй шүү дээ. Тийм болохоор эхлээд бид журам, заавраа гаргачихъя. Дараа нь бага багаар яндангуудаа цөөлнө. Шат дараатай ажлуудыг хийнэ. Ямар ч байсан Засаг даргын гаргасан

захирамжийн хүрээнд энэ өвөлдөө богино хугацааны дүрмээ гаргаад, ажил хэрэг болгоод эхэлчихье. Үр дүн гурав, дөрвөн сараас гарна. Харин дараа жилээс бид бүсчилсэн бодлогоороо бэлтгэл дөрөв, гуравдугаар бүсдээ түүхий нүүрс түлэхээ бүр больчихье. Цахилгаанаар халаалтаа шийдье. Ингэхээр төр, хувийн хэвшил, иргэд гэсэн гурвалсан харьцаа мэдэж үүснэ. Үүн дээр аль аль тал нь хүлээцтэй хандаж, хууль батлах байгууллага нь хуулиа батлаад, Хэрэгжилт, гүйцэтгэл дээр нь хяналтаа тавиад явчихъя. Дээрээс нь татаас, хөнгөлөлтүүдийг өгөөд, утааны эсрэг тэмцэх сурталчилгаа хийх, иргэдийг соён гэгээрүүлэх ажлуудаа хариуцаад, хийгээд явна. Нөгөө талаас иргэд төрөөс гарсан шийдвэрийг дагаад, нийтийн эрх ашгийг хүндэтгээд, өөрсдийнхөө санаачилгаар яндангаасаа татгалзаж, цахилгааны гэрээгээ хийгээд, халаагууруудаа тавиад явчих хэрэгтэй. Илүү боловсон технологиудыг ашиглаад явах боломж нээлттэй байна. Энэ мэтээр богино хугацаанд хийх алхмууд байгаа. Урт хугацаандаа бол бид гэр хорооллын гудамж, талбайд ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөлтийн ажлыг маш цэгцтэй хийх хэрэгтэй” хэмээн ярьжээ.

## “ЭЙС АССОШИЭЙТС БЬСБ” ХХК БАЛАНС

БАЛАНСЫН ЗҮЙЛ		2016 он
		12 сарын 31
<b>АКТИВ ХӨРӨНГӨ</b>		
<b>I</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	415 734 785,66
	Найдваргүй авлагын хасагдуулга	
<b>II</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	-
	Үл хөдлөх хөрөнгө	-
<b>III</b>	<b>НИЙТ АКТИВ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>415 734 785,66</b>
<b>IV</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	
	Татварын өр	626 168,11
	Энгийн хувьцаа	401 000 000,00
	Хуримтлагдсан ашиг/алдагдал	14 108 617,55
<b>V</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>415 734 785,66</b>

ОРЛОГЫН ТАЙЛАН		ДҮН
Үзүүлэлт		
	Үндсэн үйл ажиллагааны орлого	51 786 059,77
	Үйл ажиллагааны зардлын дүн	- 45 524 378,68
<b>VI</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>6 261 681,09</b>
	Орлогын албан татвар	- 626 168,11
<b>VII</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>5 635 512,98</b>

“Мүүн лайт финанс аудит” ХХК нь “ Эйс ассошиэйтс ББСБ”-ын 2016 оны 12-р сарын 31-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Бидний дүгнэлтээр дээрх тхайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

# ДЭЛХИЙ

## Пак Гын Хегийн нам

# “ЗҮСЭЭ ХУВИЛГАЖЭЭ”



Үргэлжлэл.  
Түүрүүч нь I нүүрт

Тус улсын Ерөнхийлөгч Пак Гын Хегийн найз Чой Сун Шил өөрийн урлаг, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сандаа Ерөнхийлөгчтэй дотно байдлаа ашиглан томоохон корпорацудаас хандив нэрийдлээр их хэмжээний авлига авч байсан нь баримттайгаар нотлогдсон байдаг. Тус хэргийн салхинд Пак Гын Хе найзаа улстөрийн үйл хэрэгтээ хөндлөнгөөс оролцуулж байсан нь илэрч, удам дагасан Ерөнхийлөгч, мөн тус улсын анхны эмэгтэй Ерөнхийлөгч гэх тодотгоолоо “утсан хүүхэддэй”, “Гэмт хэрэгтэн” гэх нэрээр сольж орхисон билээ. БНСУ-ын Сөүл

хотноо эсэргүүцийн жагсаал зохион байгуулагдаж, Пак ард түмэндээ хандсан мэдэгдлийг хэдэнтэй хийсэн ч тусыг эс олсон удаатай. Мөн парламентын гишүүд Ерөнхийлөгчдөө итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хурааж, ихэнх нь эсрэг байр суурь илэрхийлсэнээр БНСУ-ын эмэгтэй Ерөнхийлөгч суудлаасаа буусан. Эдүгээ түүнийг огцруулах эсэхийг Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэх билээ. Тэгвэл энэ мэт дуулиан дэгдсэний дараа Сэнүри намын нэр хүнд унаж, зарим гишүүд нь намаа орхиж, дэмжигчдийнх нь хувь хүртэл буурсан юм. Улмаар үүссэн нөхцөл байдлаас намаа аврах зорилгоор эрх баригч хүчнийхэн нэрээ өөрчлөхөд хүрсэн бололтой. Өмнөд Солонгос хэдийгээр

олон намын тогтолцоотой ч сүүлийн хэдэн сонгуулийн турш одоогийн “Сэнүри”, Нэгдсэн Ардчилсан нам хоёрын хооронд гол өрсөлдөөн өрнөсөөр ирсэн байдаг. Гэвч, Сэнүри түүхэндээ хэд хэдэн ч удаа нэрээ сольсон удаатай. Анх 1997 онд “Үндэсний нам” гэж байгуулагдаж байсан бол 2012 оны сонгуулийн өмнөхөн нэрээ өөрчилж, “Шинэ ертөнц” буюу Сэнүри хэмээн нэрлэж байж. Энэ онд ч гэсэн БНСУ-д Ерөнхийлөгчийн сонгууль болохоор төлөвлөгдөж буй бөгөөд мөн л сонгуулиас урьтан тус нам “Сэнүри” нэрээ “Эрх чөлөөт Солонгос” гэж өөрчилжээ. Нэрээ өөрчилсөн шалтгаанаа намын төлөөлөгч “Бид шинэчлэгдэнэ гэдгээ амлаж буйн зэрэгцээ намынхаа нэрийг

Эрх чөлөөт Солонгосын нам болгон өөрчлөхөөр шийдсэн” гэж хэлжээ. Намын нэрийг албан ёсоор шинэчлэх үйл ажиллагаа энэ сарын 13-нд зохион байгуулагдах гэнэ. Тус ёслолд улстөрийн хүчний тэргүүнүүд уригдсан байх бөгөөд тэр өдрөөс хойш “Сэнүри” намыг шинэ нэрээр нэрийдэх аж. Ямартай ч, 2012 оны парламентын сонгуульд намаа удирдан оролцож, өөрийн нэр хүндээрээ намаа аварч, ялалтад хүргэж байсан Ерөнхийлөгч Пак Гын Хе энэ удаа намынхаа нэр хүндийг унагахад голлон нөлөөлсөн гэгдэж байгаа юм. Харин удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ шинэчилсэн нам хэрхэн оролцох нь олон улсын анхаарлыг татаж байна.

### Д.Трамп Си Зиньпинд захидал бичжээ

АНУ-ын Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч Син Спайсер тус улсын шинэ Ерөнхийлөгч Доналд Трамп БНХАУ-ын дарга Си Зиньпинд захидал бичсэн талаар мэдээлжээ. Энэ нь үл хөдлөх хөрөнгийн бизнесмэн эрийн Ерөнхийлөгчийн тангаргаа өргөсний дараа Си Зиньпиний баяр хүргэсэн захидлын харуу гэнэ. Д.Трампы захидалдаа “АНУ, БНХАУ-ын талд ашиг авчрах бүтээл харилцааг бэхжүүлэхэд Си Зиньпинтэй хамтран ажиллана гэдэгтээ итгэлтэй байгаагаа” бичсэн аж. Гэхдээ энэ талаар Хятадын Гадаад хэргийн яамнаас ямар ч мэдээлэл өгөөгүй байна. Доналд Трамп, Си Зиньпин нар Трампыг

Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсны дараахан угсаар ярилцсан ч өнгөрсөн сарын 20-оос хойш буюу Трампын Ерөнхийлөгчийн тангарга өргөсөн өдрөөс хойш ярилцаагүй юм. Хятадын Гадаад хэргийн яам өнгөрсөн долоо хоногт хоёр улс нягт харилцаатай хэвээр байгаа хэмээн мэдэгдсэн билээ.

Хятадын Засгийн газрын зөвлөх, гадаад харилцааны мэргэжилтэн Ян Жэйчи Трампын Үндэсний аюулгүйн байдлын зөвлөх Майкл Финлинд БНХАУ нь АНУ-тай хамтран санал зөрөлдөж байгаа асуудлуудаа хамтдаа шийдэх байх гэж найдаж байгаа талаараа мэдэгдсэн байна.



### ГОВЬСҮМБЭР АЙМАГ

## Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар шинэ байрандаа орлоо

Говьсүмбэр аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг байсан хоёр агентлаг 2016 онд Засгийн газрын яамдын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор нэгдэж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болсон билээ. Тус газар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа, аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам, Засаг даргын орлогч Ш.Билэгтүмбэрэл, ЗДТГ-ын дарга Д.Содном, Цэргийн штабын дарга С.Бат-Эрдэнэ, ЗДТГ-ын НБХ-ын дарга С.Уранцэцэг, Сүмбэр сумын ИТХ-ын дарга Т.Түмэнбаяр, Засаг дарга П.Амарсайхан, аймгийн БСУГ-ын дарга Э.Мөнхзул, Политехник коллежийн захирал Ш.Отгонжаргал болон бусад албаны хүмүүс оролцсон байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын шинэ байрыг 200 сая төгрөгөөр “Геотайн реүд” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд тус байгууллагын онцлогоос хамааран хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх бүхий л боломжоор ханган тохижуулж засварласан байна. Ийнхүү шинэ байрандаа орсон Д.Гансүх даргатай Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хамт олны цаашдын ажилд нь амжилт хүссэн юм.

### ДАРХАН-УУЛ АЙМАГ

## Багийн Засаг дарга нар батламжаа гардав

Дархан-Уул Дархан сумын 18 багийн Иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаан энэ сарын 07-нд нэгэн зэрэг эхлэв. “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.10-д заасны дагуу БИHX-д тухайн багийн нийт өрхийн 20-30 өрх тутмаас нэг төлөөлөл оролцов хуралдаан хүчинтэйд тооцогддог. Энэ удаагийн ИНХ-д тус сумын бүх багуудын иргэдийн идэвх оролцоо 90-ээс дээш хувийн ирдэг болж өнгөрөв. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллын дагуу БИHX-ын дарга, тэргүүлэгчид, багийн Засаг даргад нэр дэвшигчдийг тодруулж сонгосон байна. Хурлын дотоод дэгийн дагуу тус хуралдаанаар нийт 18 багийн хэмжээнд багийн ИНХ-ын даргад 36, БИHX-ын тэргүүлэгчдэд 70, багийн Засаг даргад 36 хүн тус тус өрсөлдөж санал хураалтад ороллоо. Санал хураалт өндөрлөж сонгогдсон багийн ИНХ-ын дарга, тэргүүлэгчид хуралдаж иргэдийн саналаар сонгогдсон багийн Засаг дарга нарыг сумын Засаг даргад батламжуулахаар өргөн мэдүүлснээр сумын Засаг дарга батламжилж батламж, тамга тэмдэгийг нь гардууллаа. Сумын Засаг дарга Б.Азжаргал: “Манай сумын Багийн ИНХ бүх 18 багт нэгэн зэрэг амжилттай болж өндөрлөлөө. Бүх багуудын иргэд идэвхтэй сайн оролцож баг тус бүрт ирд 90-ээс дээш хувьтай оролцсон нь өндөр үзүүлэлт юм. Багт нэр дэвшсэн бүх хүмүүс мөрийн хөтөлбөрөө танилцуулж тэдгээрээ сонголт хийж иргэд маань багийнхаа удирдлагуудыг сонгосон нь иргэдийн маань өөрсдийнх нь сонголт юм. Тиймээс иргэдийнхээ итгэлийг хүлээж сонгогдсон бүх багийн Засаг дарга нарынхаа ажлыг сумаас байнга дэмжиж ажиллах болно” гэв.

### ДОРНОГОВЬ АЙМАГ

## Япон улсын элчин сайдын зөвлөх Кикүчи Минору Дорноговь аймаг айлчиллаа

Япон улсаас Монгол улсад суугаа элчин сайдын зөвлөх Кикүчи Минору “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлуудтай танилцах зорилгоор энэ сарын 7, 8-нд Дорноговь аймаг айлчиллаа. Уулзалтын үеэр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Б.Баярмаа аймгийн аялал жуулчлал, хөдөө аж ахуй, томоохон бүтээн байгуулалтууд болон гадаад харилцаа тэр дундаа Дорноговь аймаг, Шүзүока муж хоорондын

хамтын ажиллагааны талаар мэдээлэл хийсэн юм. Мөн аймгийн Засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэг Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийн сурч боловсрох таатай орчин нөхцөлийг байнга бүрдүүлж байгаад талархаж байгаагаа илэрхийлж, цаашид Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд Дорноговь аймгийн Музей сургалт, судалгааны төв, Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 болон 5 дугаар сургуульд хэрэгжүүлэх боломжтой төслиүүдийг танилцуулсан юм.

### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

## Өвөрхангай аймгаас долоон улсын аварга малчин төрлөө

Засгийн газрын энэ сарын 8-ны өдрийн хуралдаанаар Улсын аварга малчин, Улсын хошой, Улсын аварга саальчин, Улсын аварга фермер, Улсын тэргүүний тариаланч хамт олон, Улсын тэргүүний тариаланчдыг шалгарууллаа. Өвөрхангай аймгаас Улсын аварга малчин долоон, Улсын хошой аварга малчин нэг, Улсын аварга тариаланч нэг, Улсын аварга саальчин нэг шалгарсан байна. Тодруулбал, Улсын аварга малч-наар Өлзийт сумын нэгдүгээр багийн малчин Бат-Өлзийгийн Ганболд, Гучин-Ус сумын хоёрдугаар багийн малчин Цэрэндондовын Батбаяр, Бат-Өлзий сумын нэгдүгээр багийн малчин Төмөр-Очирын Эрдэнэбат, Нарийнтээл сумын гуравдугаар багийн малчин

Сэрээгийн Дондогсамбуу, Хайрхандулаан сумын дөрөв-дүгээр багийн малчин Бат-Өлзийгийн Отгоннасан, Төгрөг сумын тавдугаар багийн малчин Мөнхөөгийн Баянмөнх, Есөнзүйл сумын гуравдугаар багийн малчин Даржаагийн Ганбат нарыг шалгаруулжээ. Мөн 2013 онд Монгол улсын аварга малчнаар шалгарч байсан Бат-Өлзий сумын дөрөвдүгээр багийн малчин Найтал овогтой Төмөрбат Улсын хошой аваргаар тодорсон бол Зүүнбаян-Улаан сумын хоёрдугаар багийн малчин Дэлэгийн Долгор Улсын аварга саальчин, Төгрөг сумын гуравдугаар багийн малчин Дашхүүгийн Энхбаатар Улсын аварга тариаланчаар тус тус шалгарсан байна.

# №13 ЯПОНД ТҮР ОРШИН СУУГЧИД “ДААТГАЛААС ГАРСНЫ МӨНГӨ” АВАХ БОЛОМЖТОЙ



Манай сонин долоо хоног бүрийн баасан гарагт нийгмийн даатгалын үйлчилгээ, түүний талаархи түгээмэл асуулт харилцлын буланг Японы олон улсын халтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын Монгол Улсад хэрэгжүүлж буй Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн тэргээжилтнүүдтэй хамтран бэлтгэн хүргэж байгаа билээ. Уншигчдын төдийлөн мэддэггүй ч, заавал мэдэж байх ёстой түгээмэл асуултад Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн ахлах зөвлөх Яташита Маторү харилуулав байна.

Өмнөх дугаарт Япон улсад ажиллаж амьдарч буй Монгол улсын иргэд албан журмаар даатгалд хамрагдах үүрэгтэй. Даатгалд хамрагдсанаар тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах боломжтой талаар ярьсан. Гэхдээ, гадаад хүн Япон улсад түр хугацаагаар оршин суух тохиолдолд өндөр насны тэтгэвэр авахгүй тул төлсөн шимтгэлийн үр шимийг хүртэхгүй гэсэн үг үү? Япон улсад даатгалын шимтгэлээ 10 жил төлж байж өндөр насны тэтгэвэр авах эрх үүсдэг. Жишээлбэл, 10 жил тасралтгүй шимтгэлээ төлсөн 65 нас хүрсэн иргэн өндөр насны тэтгэвэр авах боловч есөн жил шимтгэл төлсөн бол тэтгэвэр авах боломжгүй. Тиймээс 3-5 жил Япон улсад оршин суугаад

нутаг буцсан бол өндөр насны тэтгэвэр авах боломжгүй юм. (Гэхдээ гадаад хүн шимтгэл төлж буй хугацаандаа тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч болно /өмнөх дугаарт дэлгэрэнгүй тайлбарласан/). Ийм сул тал байдаг учир тодорхой хугацаанд шимтгэл төлсөн гадаад иргэдэд “даатгалаас гарсаны мөнгө” олгодог. Энэ талаар Японы тэтгэврийн даатгалын байгууллагын вэб хуудаст дэлгэрэнгүй тайлбарласан байдаг учир энэ удаа яагаад “даатгалаас гарсаны мөнгө” олгодог болсныг тайлбарлая. Өмнөх дугаарт хэлсэнчлэн Япон улсын тэтгэврийн тогтолцоо нь энэ улсад амьдарч буй бүх хүнийг эрсдэлээс (өндөр нас, тахир дутуу, тэжээгчээ алдах) хамгаалах зорилготой. Ялангуяа тахир дутуу болох, нас барах үгүйг урьдчилж мэдэх

боломжгүй учир даатгалд хамрагдаж, эрсдэл үүссэн үед хамгаалагдах боломжтой болно. Гадаад дотоодын иргэн гэлтгүй Япон улсад оршин сууж буй бүх хүн тэгш эрхтэйгээр нийгмийн даатгалд хамрагддаг. Харин, өндөр насны тэтгэвэр дээр тэтгэврийн насыг бүрэн тооцож болно. Тиймээс заавал 10-с доошгүй жил шимтгэл төлөх нөхцөлтэй байдаг. Энэ нь түр хугацаагаар оршин суух гадаад иргэдийн эрх ашигт нийцэхгүй тул “даатгалаас гарсаны мөнгө” олгогддог. Япон улсад оршин сууж буй хугацаандаа тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр аваагүй нутаг буцсан гадаад хүн энэ мөнгийг авдаг. Гэхдээ “даатгалаас гарсаны мөнгө” авсан тохиолдолд тухайн гадаад хүний шимтгэл төлсөн мэдээлэл устдаг.

# СПОРТ

“МАНЧЕСТЕР ЮНАЙТЕД” 2016 ОНД ХАМГИЙН ОЛОН  
ӨМСГӨЛ ЗАРЖЭЭ

VIII нүүрт

ПАРИСЫН “ИХ ДУУЛГА” НЯМ ГАРАГТ  
ЭХЭЛНЭ

VIII нүүрт



АМЖИЛТЫН ЭЗЭН



## Серена Уильямс:

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Олимпын дөрвөн удаагийн аварга, “Их дуулга” цувралын ганцаарчилсан төрөлд 22, хосын төрөлд 14 удаа түрүүлсэн, дэлхийн чансааны тэргүүнд бичигддэг Америкийн теннисчин Серена Уильямсын ярилцлагыг эх хэлнээ хөрвүүлэн хүргэж байна. Тэрбээр эдүгээ 35 настай бөгөөд их спортод амьдралынхаа 20 гаруй жилийг зориулжээ. Түүнчлэн тамирчин бүсгүй “Түргэн тусламж”, “Хууль ба эмх журам”, “Үсний шоу” зэрэг кинонд тоглож дэлгэцийн урлагт хөл тавьсан билээ.

Төгсгөл нь VII нүүрт

## ТЕННИСИЙГ ОРХИХ ТУХАЙ ХЭЗЭЭ Ч БОДОЖ БАЙСАНГҮЙ

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

### Бөхчүүдийг сэргээшийн шинжилгээнд хамруулна



Тэрэл зургийг Г.АРГУУЖИН

Монголын үндэсний бөхийн холбооноос улсын баяр наадмаас бусад үед бөхчүүдээ сэргээшийн шинжилгээ авахаар боллоо. Үндэсний баяр наадамд шөвгөрсөн 32 бөхөөс шинжилгээ авдаг. Наадмаас бусад үеийн шинжилгээнд хамруулах шаардлагатай бөхчүүдийг сонгох зорилгоор энэ сарын 8-аас эхлэн нууцаар санал авч эхэллээ. Өөрөөр хэлбэл, бөхчүүд тусгай санал асуулгын хуудсанд улс, аймаг, сумын цолтой тус бүр найман бөхийн нэр бичих ажээ. Мэдээж заавал найман бөх бичихгүй, шаардлагатай хүмүүсийн нэрсээ бичих боломжтой аж. Одоогоор Монголын үндэсний бөхийн холбооноос Архангай

аймгийн “Бөх билигт” дэвжээ, “Алдар” спорт хороон дээр бэлтгэл хийж байгаа бөхчүүд, “Ховд” дэвжээ, “Хилчин” спорт хороо, Говь-Алтай, Увс, Өмнөговь, Хөвсгөл, “Их шавь” дэвжээ зэрэг нийт 300 гаруй бөхөөс санал аваад байгаа аж. Цаашид бусад дэвжээ болон аймгийн бөхчүүдээс үргэлжлүүлэн санал авах юм байна. Үүнээс гадна бөхийн хорхойтнууд үзэгчдээс ч санал авахаар болжээ. Хоёр болох Их Монгол Шаравамц аваргын мэндэлсний 140 жилийн ойд зориулсан улс, аймгийн алдар цолтой 224 бөхийн барилдаанд үзэгчдээс саналаа өгөх боломжтой юм байна.

### Ц.Алтантөгс, Б.Болормиа нар спортын гимнастикийн багийг дасгалжуулна

2017-2020 оны олимпын циклд олимпын төрөл болох спортын гимнастикийн эрэгтэй болон уран сайхны гимнастикийн дасгалжуулагчийн сонгон шалгаруулалт хоёрдугаар сарын 5-нд боллоо. Сонгон шалгаруулалтад нийт есөн дасгалжуулагчийн материал (спортын гимнастикийн-5, Уран сайхны гимнастикийн-4) ирснээс шалгалтад зургаан дасгалжуулагч

өрсөлдөв. Байнгын бус шигшээ багийн дасгалжуулагчийн сонгон шалгаруулалтад спортын гимнастикийн эрэгтэй ОУХМ, Сингапур-2010 залуучуудын олимпын наадмаас алтан медаль эх орондоо авчирсан Ц.Алтантөгс хамгийн өндөр оноо авч тэргүүлсэн. Уран сайхны гимнастикийн төрлөөр Спортын мастер, дасгалжуулагч Б.Болормиа дасгалжуулагч шалгарлаа.

Сонгон шалгаруулалтын дагуу Ц.Алтантөгс, Б.Болормиа нарыг спортын гимнастик, уран сайхны гимнастикийн дасгалжуулагчаар ажиллуулах хүсэлтийг Үндэсний шигшээ багийн албаны ажлын хэсэгт өгчээ. Үндэсний шигшээ баг бүрдүүлэх, тамирчдыг сонгон шалгаруулах журмын дагуу орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн томилох эсэх эцэслэн шийдэх юм байна.

### Хөлбөмбөгийн охидын шигшээ Хонгконгийг зорилгоо

Монголын улсын хөлбөмбөгийн 14 хүртэлх насны охидын шигшээ баг анхныхаа олон улсын тэмцээнд оролцохоор өчигдөр өглөө Хонгконгийг зорилгоо. Байгуулагдаад жил ч болоогүй Монголын эмэгтэйчүүдийн анхны шигшээ баг Хонгконг улсын “Жокэй” клубын нэрэмжит тэмцээнд оролцохоор эх орноосоо мордож байгаа нь энэ юм. Тус тэмцээнд Монгол, Хонгконг, Тайланд, Лаос гэсэн дөрвөн улсын 14 хүртэлх насны охидын шигшээ баг оролцож, энэ сарын 13-нд аваргуудаа тодруулна. Манай

охидын шигшээ эхний тоглолтоо Тайландын багтай өнөөдөр, хоёр дахь тоглолтоо 11-нд Лаосын багтай хийх бол сүүлийн тоглолтоо зохион байгуулагч Хонгконгийн шигшээ багтай 13-ны өдөр хийснээр тэмцээнээ өндөрлүүлэх юм байна. МХБХ-ны Ерөнхийлөгч А.Ганбаатар өчигдөр охидын шигшээ багийн тоглогчид болон албаны хүмүүстэй уулзаж, үдэж өглөө. Охидын шигшээ багийн ахлах дасгалжуулагчаар Япон улсын мэргэжилтэн Ики Ёоүжү ажиллаж байгаа ажээ.

### Н.Төгсцогтын найм дахь өрсөлдөгчийн нэр тодроогүй байна

Мэргэжлийн боксын рингэнд долоон үнэмлэхүй ялалт авсан олимп, ДАШТ-ий мөнгөн медальт, гавьяат тамирчин Н.Төгсцогтын ээлжит тулааны тов гарсан билээ. Тэрбээр ирэх сарын 12-нд найм дахь тулаанаа хийхээр болсон. Харин одоогоор түүнтэй өрсөлдөх тамирчны нэр тодроогүй байгаа юм. Н.Төгсцогт долоо дахь ялалтаа байгуулснаар жингийнхээ 1514 тамирчнаас 73 дугаар байрт эрэмбэлэгдэж байна. Тэрбээр гурван тулаан хийсний дараа дэлхийн аваргын бүсний төлөө 2017 оны сүүлчээр өрсөлдөх юм.



## “ЭЙС АССОШИЭЙТС ББСБ” ХХК БАЛАНС

БАЛАНСЫН ЗҮЙЛ		2016 он 12 сарын 31
<b>АКТИВ ХӨРӨНГӨ</b>		
<b>I</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	97 075 741,02
	Найдваргүй авлагын хасагдуулга	- 22 170 000,00
	Бусад авлага	483 025 000,00
<b>II</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	557 930 741,02
	Үл хөдлөх хөрөнгө	13 451 139,00
	Хуримтлагдсан элэгдэл	- 11 856 727,75
	Биет бус хөрөнгө	10 214 250,00
<b>III</b>	<b>НИЙТ АКТИВ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	569 739 402,27
<b>IV</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>	
	Татварын өр	
	Энгийн хувьцаа	
	Дахин үнэлгээний нөөц	
	Хуримтлагдсан ашиг/алдагдал	
<b>V</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>	

### ОРЛОГЫН ТАЙЛАН

Үзүүлэлт		
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	
Үйл ажиллагааны зардлын дүн	- 14 967 968,81	132 000,00
Үндсэн бус үйл ажиллагааны зардлын дүн	- 143 275 000,00	1 433 609 700,00
<b>VI</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	- 158 242 968,81 - 652 309 700,00
	Орлогын албан татвар	- 211 692 597,73
<b>VII</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	- 158 242 968,81 569 739 402,27

“Мүүн лайт финанс аудит” ХХК нь “Эс Жи Капитал УЦК” ХХК-ын 2016 оны 12-р сарын 31-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан,

тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Бидний дүгнэлтээр дээрх тхайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

# МЭДЭЭЛЭЛ

## ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН ДҮНГИЙН ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.4-д заасны дагуу Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн IV улиралд Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллого явуулдаг бөгөөд уг тооллогыг 2015 оны арванхоёрдугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон явуулж дүнг нэгтгэн гаргалаа.

Тооллогод төрийн болон орон нутгийн өмчийн өөрийн хөрөнгө хамрагдсан бөгөөд нийт 6086 нэгж хуулийн этгээд (төрд 1128, орон нутгийн өмчид 4958) хамрагдлаа. Зохион байгуулалтаар ангилвал төрийн (орон нутгийн) байгууллага, албан газар 5026, Засгийн газрын тусгай сан 14, төрийн (орон нутгийн) өмчит аж ахуйн тооцоот (улсын төсөвт) үйлдвэрийн газар 230, хувьцаат болон хязгаарлагдмал харьцуулагатай компани 106, төсөл, сан (орон нутгийн хөгжлийн сан (төрөл бүрийн) 689, Монголбанк (зөвхөн үндсэн хөрөнгийг тоолсон), Төрийн банк, Хөгжлийн банк орж байгаа бөгөөд тэдгээрт нийт 213402 хүн ажиллаж байна. Тооллогод хүүхдийн цэцэрлэг 790, нэгдсэн болон сум дундын эмнэлэг 129, сумын эмнэлэг 245, соёлын төв, соёлын ордон 335, театр 25, номын сан 23, биеийн тамир спортын байгууллага 38, албан бус боловсрол, насан туршийн боловсролын 23, сургууль 616, сум дундын ойн анги 35, ахмад, хүүхдийн сувилал 46 хамрагдлаа. Мөн орон нутгийн өмчийн өмчийн тооллогод хамрагдсан нийт 298 өрхийн эмнэлэг нь “нөхөрлөл”-ийн гэрчилгээтэй, нийт 26 Ахмадын хороо нь төрийн бус байгууллагын гэрчилгээтэй боловч хөрөнгө нь орон нутгийн өмч байгаа зөрчил байна.

### I. Нийт хөрөнгийн дүн

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогод 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тасалбар болгосон 30,074.9 (гучин их наяд далан дөрвөн тэрбум есөн зуун сая) тэрбум төгрөгийн нийт хөрөнгө хамрагдсанаас 17,150.9 (арван долоон их наяд нэг зуун тавин тэрбум есөн зуун сая) тэрбум төгрөгийн төрийн болон орон нутгийн өмчийн өөрийн хөрөнгө байна. Төрийн өмч болон аймаг нийслэлийн өмчийн нэгдсэн дүнг өмчлөлийн төрлөөр хавсралтад тусгав.

#### Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын дүнгийн товчоо

/тэрбул.төг/

ӨМЧЛӨЛ	Нийт хөрөнгийн дүн	Үүнээс:		Өр төлбөрийн дүн	Төрийн өөрийн хөрөнгө	Төрийн өмчийн цэвэр дүн
		Эргэлтийн	Эргэлтийн бус хөрөнгө			
Төрийн	25,687.5	8,424.3	17,263.3	12,428.7	13,258.8	12,425.4
Орон нутгийн	4,387.4	460.0	3,927.4	495.4	3,892.1	3,839.3
Нийт дүн	30,074.9	8,884.3	21,190.7	12,924.1	17,150.9	16,264.6

Төрийн болон орон нутгийн өмчийн нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хасч, өөрийн өмчийн дүнг гаргасан бөгөөд түүнээс өмчлөлийн оролцооны хувиар тооцсон 16,264.6 (арван зургаан их наяд хоёр зуун жаран дөрвөн тэрбум зургаан зуун сая) тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгө байна.

Тооллогын дүнг Төсвийн ерөнхийлөн захирагчдаар ангилан хавсралтад тусгав.

Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын дүнд эд хөрөнгө зах зээлийн үнэлгээгээр бус санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан болно.

### II. Үндсэн хөрөнгийн дүн


#### Биет хөрөнгийн тооллогын дүнг нэгтгэн гаргавал:

/тэрбул.төг/

д/д	Өмчийн төрөл	Нийт биет хөрөнгийн дүн /2015.12.31/		
		Балансын үнэ	элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Орон нутгийн	6,130.3	2,238.3	6,130.3
2	Төрийн	16,002.8	5,741.7	16,002.8
	НИЙТ ДҮН	22,133.1	7,980.0	22,133.1

Тооллогын дүнгээрх биет хөрөнгийн хэмжээг 2012 оны тооллогын дүнтэй харьцуулж үзвэл нийт дүнгээрээ 1.8 дахин өссөн дүнтэй байна. Энэхүү өсөлтөд зарим хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт болон сүүлийн дөрвөн жилийн хөрөнгө оруулалтын дүн голлох нөлөө үзүүлж байна.

#### Биет үндсэн хөрөнгийн бүтэц:



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Тооллогын дүнгээр нийт 42700 ширхэг, 9,869.3 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий барилга тоологдоно 345.6 тэрбум төгрөгийн 20711 ширхэг бүрэн элэгдэж үлдэх өртөггүй болсон боловч ашиглагдаж байна.

Улсын хэмжээгээр нийт 2747.5 тэрбум төгрөгийн зам, гүүрийн байгууламж тоологод хамрагдсанаас 2676.4 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий, 106,808.94 км зам, 7220.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий, 29,099.5 уртааш метр, 836 ширхэг гүүрийн байгууламж тоологдоо.

Тооллогод нийт 8721 ширхэг, 88.5 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий худаг тоологдоно 10 хувь буюу 874 ширхэг худаг ашиглалтгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн нийт 1,280.6 тэрбум төгрөгийн балансын үнэ, 539.6 тэрбум төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 25679 ширхэг тээврийн хэрэгсэл хамрагдсан нь 40-48 хувийн элэгдэлтэй байна.

Тооллогод 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 2,565.3 тэрбум төгрөгийн дуусаагүй барилга байгууламж тоологдоно 317 нь төрийн өмчид, 522 ширхэг нь орон нутгийн орон нутгийн өмчид байна. Тэдгээрийн дотор он дамжин санхүүжилт хийгдээгүй барилгууд цөөнгүй байна.

Монгол Улсаас гадаад улсад 44 дипломат төлөөлөгчийн газар (Элчин сайдын яам, Ерөнхий консулын газар г.м) байгаа нь тооллогод бүрэн хамрагдсан.

Тооллогоор нийт 194.0 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлгүй, 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө дутагдсан, 32.6 тэрбум төгрөгийн хөрөнгө маргаантай байгааг илрүүлээ.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байгууллагад нийт 9676 нэгж талбарын 118473.9 га газар эзэмшиж, ашиглах эрх тоологдоноос 110 нэгж талбар газрын гэрчилгээг авч баталгаажуулж, 4967 нэгж талбар газрыг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас 2013-2015 онд нийт 442.4 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргасны 65 хувь нь үндсэн хөрөнгө, 10 хувь нь эргэлтийн хөрөнгө бэлтгэхэд, 15 хувь нь зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдсан байна. Нийт санхүүжилтийн долоон хувь буюу 31.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй орхисон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн өөрийн хөрөнгийг түрээслүүлсэн нийт 1935 гэрээ байгуулсны 1052 нь төрийн өмчид, 883 нь орон нутгийн өмчид хамаарч байгаа бөгөөд түрээсийн жилийн нийт 7.6 тэрбум төгрөгийн орлогоос 2.8 тэрбум төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.

Төрийн өөрийн өмчийн түрээсийн нэгж талбайн төлбөрийн жишиг үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2016 онд шинэчлэн баталж төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Өөрийн эзэмшлийн байргүй, төрийн болон орон нутгийн өмчийн нийт 401 (төрийн 340, орон нутгийн 61) байгууллага бусдын 42922 м.кв талбай бүхий байрыг түрээсэлж жилд 2.1 тэрбум төгрөгийн түрээсийн зардал төлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын дүнгээр зарим асуудлуудыг шийдвэрлүүлэхээр Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төсөл, Тэмдэглэлийн төслийг хэлэлцүүлж байна.

#### Засгийн газрын төвшинд:

- Концессын гэрээгээр бий болж буй хөрөнгийг төрийн өмчид бүртгэх асуудлыг цэгцлэх
- Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагад эзэмшүүлсэн газрын үнэлгээг тогтоож, бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлэх
- Монгол Улсад байгаа болон гадаадад байгаа төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх эсэх асуудлыг шийдвэрлэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бий болж буй хөрөнгийн бүртгэлийг сайжруулах арга хэмжээ авах
- ОХУ-ын Москва хот дахь Элчин сайдын яамны II байр, Улаан-Үд хот дахь Консулын газрын барилга тус тус хөрөнгө оруулалтын маргаантай асуудлыг шийдвэрлэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн хурлын төвшинд:
- Төрийн байгууллагуудад ашиглах суудлын автомашины тоо, төрлийг шинэчлэн тогтоож мөрдүүлэх
- Тооллогоор дутагдсан, бүртгэлгүй, маргаантай байгаа хөрөнгийг бүртгэлд тусгах, төрийг хохиролгүй болгох, маргааныг шийдвэрлэх саналыг боловсруулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажлыг хийж гүйцэтгэх
- Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн санг бүрэн бүрдүүлэх, боловсронгуй болгох
- Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, өгөөжийг нэмэгдүүлэх
- төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газартай хамтран тулгалт хийж, зөрчил дутагдлыг арилгах зэрэг болно.

MMINFO АПП

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...



TATAAX  
PLAY STORE



TATAAX  
APP STORE



# СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭН

## Серена Уильямс: Теннисийг орхих тухай хэзээ ч бодож байсангүй



Төгсгөл. Түүрүүч нь V нүүрт

Их спортод та олон жил амьдарлаа. Амьдралынхаа бараг 20 жилийг теннис тоглож өнгөрүүлсэн байна шүү дээ. Гэтэл одоо ч теннис хөгжилтэй санагддаг уу?

Тийм. Анх 1998 онд теннис тоглож эхэлсэн юм. Тухайн үеийн Моника Селеш, Штеффи Граф, Пит Сампрас гэх мундгуудыг шүтэж, харж баясаж л өссөн. Одоо ч өөрчлөгдөөгүй ээ. Тенниснээс л сэтгэлийн таашаал мэдэрдэг.

Та Гранд Сламд Ш.Граффын тогтоосон ганцаарчилсан рекордыг эвдэж чадаагүй л байна. Ер нь тоглож байхдаа энэ талаар боддог уу?

Бодно оо. Гэхдээ бүх зүйл

ингээд төгсчихгүй. Боломж үргэлж байдаг. Гаргахыг хүссэн амжилтынхаа үзүүрээс маш олон удаа атгаад алдаж байлаа.

Уимблданы аварга шалгаруулах тэмцээн тун удахгүй болно. Тус тэмцээнд ямар стратегиар оролцох бодолтой байна вэ?

Аваргаа хамгаална. Мэдээж, сонирхолтой тоглолтууд их болох байх. Хөгжилтэй байхыг хүсч байна. Дээр нь талбайд түрэмгий тоглолт үзүүлнэ гэж төлөвлөсөн.

Рио де Жанейрогийн Зуны олимпод та оролцсон.

Тэр тэмцээний талаар одоо бидэнд сонирхуулж болох уу?

Зика вирусийн халдвар авчихгүй юмсан л гэж бодож байлаа. Тэгээд хаана ч явсан өөрөө өөрийгөө халдвараас хамгаалж явсан шүү.

Таныг дэлхийн хамгийн аугаа тамирчин гэдэг. Та үүнийг яаж хүлээж авдаг вэ. Бодитой тодорхойлолт мөн үү?

Би мэдэхгүй байна аа. Хэлэхэд хэцүү юм. Өдөр бүр л хамгийн шилдэг тамирчин байхыг хичээдэг. Гэхдээ бүтэлгүйтэх өдрүүд бишгүйдээ л бий. Нэг удаа ердөө 30 минутад л ялагдаж, талбайг орхиж байлаа. Тэр өдөр бүх хүчээ дайчилж, хамгийн сайнаараа л тоглосон. Тэгэхээр би аугаа тамирчин мөн гэж үү. Сайн мэдэхгүй юм. Гэхдээ би аугаа тамирчин болж чадна.

Одоо танд дасгалжуулагч хэрэгтэй юу. "Зүгээрээ, өнөөдөр чамайг хамгийн сайн нь байна гэдгийг би мэдэж байна", эсвэл "Талбайгаа дахиад эзэгнэ" гэж хэлдэг хэн нэгэн хэрэгтэй гэж бодохгүй байна уу?

Надад магадгүй "Талбайгаа дахин эзэгнэ" гэж хэлдэг дасгалжуулагч хэрэгтэй байх. Сайн тоглож чадахгүй л бол сэтгэлээр уначихдаг төрлийн хүн шүү дээ би. Тэгэхээр надад

өөрөөс минь илүү итгэдэг, надтай хатуу ажиллах хүсэлтэй хүн хэрэгтэй. Миний ямар арга барил нь буруу, эсвэл ямар алдаа гаргаж буйгаа би өөрөө мэдэхгүй. Зөвхөн дахиад оролдоод үзэх хэрэгтэй л гэдгээ мэддэг.

Венус та хоёр өнгөт арьстай. Талбайд тоглохдоо юу боддогийг тань хүмүүс төдийлөн мэдэхгүй байх?

Хүмүүстэй тааралдах үед тэд "Охин минь, би чиний тоглолт бүрийг үздэг, бас чиний төлөө залбирдаг шүү" гэж хэлдэг. Тэдний үг надад маш их эрч хүч өгдөг юм. Харин заримдаа талбайд гарахдаа "Тэд миний талаар юу гэж бодож байгаа бол. Намайг ялаасай гэж хүсэхгүй байгаа болов уу. Миний өгч чадах зүйл юу билээ" гээд л бодно. Энэ бүхэнтэй тэмцэхийн тулд илүү сайн тоглох хэрэгтэй л гэж боддог.

Тэгвэл хамгийн гашуун ялагдал тань юу вэ?

Надаас өөр харамсалтайгаар ялагдсан тамирчин байдаггүй байх. Аль ч спортод. Би ялахыг л хүсдэг, харин ялагдахыг үзэн яддаг.

2015 онд АНУ-ын нээлттэй тэмцээний ялагдлын дараа хэрхэн талбайд эргэн ирсэн бэ?

Би илүү их хөдөлмөрлөсөн. Юу буруу хийсэн, хаанаа алдсанаа харж, суралцсан. Тэр үед дасгалжуулагч маань "Тэмцээн, тоглолтод чи оноо авахдаа дараагийн минутад яахаа боддоггүй. Одоо Уимблдонд анхаарлаа төвлөрүүл. Гэхдээ чи өнөөдрийнх шиг ялагдах ёстой" гэж хэлсэн. Би алданаасаа суралцаж, туршлага хуримтлуулах хэрэгтэй байсан юм.

АНУ-ын нээлттэй тэмцээнд ялагдсаны чинь дараа Дрейк твиттерт амьдаараа идүүлэх дөхсөн. Үүнийг хэр шударга явдал гэж та бодож байна вэ?

Үгүй ээ. Би шударга явдал

гэж бодохгүй байна. Ялсан, ялагдсан ч талбайд тоглож байгаа хүн нь би. Ямар ч зүйлд өөр хэн нэгнийг буруутгахгүй. Тэр өдөр надтай сайн өрсөлдөгч таарсан. Би өөрөө сайн байж чадаагүй.

Серена та одоо 35 нас хүрч байна. 30 нас гэдэг хүмүүсийн, ялангуяа тамирчдын ид үе. Таны хувьд 30 хүрсний дараа теннис хэцүү санагдаж байна уу, эсвэл?

30 насыг жинхэнэ хийж бүтээх үе гэж хэн хэлсэн билээ. Би хэн энэ дүрмийг зохиосныг мэдэхийг хүсч байна. Нэг удаа ээжтэйгээ ярьж байгаад "Бурхан минь 30 хүрчихлээ гэж үү" гэхэд, "Хүн 30 хүрэхээрээ 20-тойгоосоо илүү хүчтэй болдог юм" гэж ээж хэлж байсан. Тухайн үед ээждээ итгээгүй ч одоо бодоход хамгийн үнэн үг байж. Үнэхээр эргэлзээгүй 20-тойгоосоо ч илүү сайн тоглодог болсон. Энэ үедээ хүн илүү тооцоотой, эрч хүчтэй, хурдтай болдог юм байна.

Та хүүхдийн талаар ямар бодолтой байдаг вэ. Өөрийн гэсэн гэр бүлтэй болохыг хүсдэг үү?

Мэдээж, би нэг л өдөр хүүхэдтэй болно. Ухаан орсон цагаасаа л хойш хүсдэг байсан. Гэхдээ жаахан нас ахисныхаа дараа. Одоо хүүхэдтэй болоход хэтэрхий эрт байна. /инээв/

Нас ахих тусам хүн эцэг, эхийн үүрэг хариуцлагыг илүү бодитой ухамсарладаг байх, тийм үү?

Тийм шүү. Өчигдөр Венустай энэ талаар ярьж байгаад "Би дэндүү залуу байна" гэж тоглоом шоглоом болгон хэлж байсан юм. Илүү буурь суурьтай болж, томоожиж ээж болоход бэлэн болсон цагтаа хүүхэдтэй болохыг хүсч байна.

Бидний ихэнхи нь танай эгчийн мэднэ. Венустай хамт байхад хүүхэд байх үеэ чинь өөрчлөгдсөн зүйл бий юу?

Нэг гудамжны наана, цаана амьдарч байгаад сарын өмнө

манайх нүүсэн. Өөрийнхөө эрх чөлөөг олсон /инээв/. Үнэндээ түүнээс хол байхыг хүсдэггүй. Миний юмнууд одоо ч тэднийг байгаа учраас нүүсэн гэж хэлж болохгүй байх. Хүүхэд байх үеэс хойш юу ч өөрчлөгдөөгүй. Бид дэндүү ижилхэн.

Венусын тоглолтоос та юу сурсан бэ?

Венус шегрена синдромтой. Гэсэн ч, теннисээ тоглосоор байгаа нь үнэхээр гайхалтай санагддаг. Тэмцээнд ч ялалт байгуулсаар явна. Нийгэм түүний талаар "тэр өвчтэй, юу ч чадахгүй" гэж ярихыг тэр хүлээн зөвшөөрдөггүй. Намайг юу хийхээ ч мэдэхгүй байх үед тэр л надад тусалж, илүү эерэг хүн болоход тусалсан.

Серенагийн өнгөрөгч хавар Снапчатад тавьсан твекринг бүжиг бүжиглэж буй хэсэг миний хамгийн дуртай бичлэгийн нэг. Тэр талаар ярихгүй юу?

Тэр өдөр ганц зураг авхуулахын тулд үүрийн 3:30 цагт гэрээсээ гарсан. Үд болтол бүжиглээд, үнэхээр их ядарч билээ. Тэгээд л твекринг зааж буй бичлэгээ хийж эхэлсэн юм. "Өгзөгөө ажиллуул, гуяа нийлүүл" гээд л.

Загварын талаар ярьж гэж бодлоо?

Намайг бүр жаахан байхад ээж минь надад юм оёхыг заасан. Тэгээд тоглодог хүүхэддэндээ хувцас оёдог байлаа. Харин энэстээ 1999 онд загварын чиглэлээр сургуульд суралцсан. Тэнд хувцас загварын мэдэгдэхүүнтэй болсон хэрэг. Манай ангийн хүүхэд бүр л ямар нэг зүйлдээ авьяастай байж билээ.

Мая Анжелоу таны дуртай яруу найрагч гэсэн байх аа?

Би түүний "Ер бусын эмэгтэй"-д дуртай.

Танд ер нь теннисний спортыг орхих бодол бий юу?

Теннисийг орхих тухай би хэзээ ч бодож байсангүй.

### МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН ВЭБ САЙТАД АДМИН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

**Тавигдах шаардлага:**

- Сэтгүүл зүй болон программ хангамжийн чиглэлээр их дээд сургууль төгссөн
- Мэдээллийн сайтад мэргэжлээрээ ажилласан зохих туршлагатай байх
- EDIUS, PHOTOSHOP болон бусад өргөн хэрэглээний программ дээр ажиллах чадвартай
- Видео болон аудио файл монтажлах, хөрвүүлэх дадлага туршлагатай
- Багаар ажиллах чадвартай

**Бүрдүүлэх материал:**

- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүлжлсэн дугтуйд хийж 2017 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг  
Хувьсгалчдын зам-3  
Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз  
Хүний нөөцийн алба  
Утас: 325802

### МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗЭД ЭВЛҮҮЛГИЙН НАЙРУУЛАГЧ СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

**Ажлын байранд тавигдах шаардлага:**

- Радио телевизийн чиглэлээр найруулагч, компьютер графикчийн мэргэжлээр төгссөн байх
- Телевиз, студи, продакшнд 2-3 жил эвлүүлэгч, эвлүүлгийн найруулагчаар ажилласан
- Интернет, компьютерийн хэрэглээний болон эвлүүлгийн программуудыг бүрэн эзэмшсэн, телевизийн техникийг ашиглах, техникийн ба дизайны шийдэл гаргах, монтаж хийх
- Монтаж, бичлэгийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадвартай байх
- Багаар ажиллаж, ачаалал даах чадвартай байх
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй

**Бүрдүүлэх материал:**

- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүлжлсэн дугтуйд хийж 2017 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг  
Хувьсгалчдын зам-3  
Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз  
Хүний нөөцийн алба  
Утас: 325802

### МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗ ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ АЖИЛЛАХ ХУРААМЖИЙН ТАСГИЙН ДАРГА СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

**Тавигдах шаардлага:**

- Санхүү, нягтлан бодох бүртгэлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Санхүү, бүртгэл тооцооны ажлыг 3-аас доошгүй жил эрхэлсэн туршлагатай
- Тайлан баланс гаргах чадвартай,
- Бие даан болон багаар ажиллах чадвартай
- Хувийн зохион байгуулалт сайтай, бүтээлч санаачлагатай
- Цаашид тогтвор суурьшилтай ажиллах

**Бүрдүүлэх материал:**

- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Их, дээд сургууль төгссөн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүлжлсэн дугтуйд хийж 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3  
Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз  
Хүний нөөцийн алба  
Утас: 325802

## СПОРТ

FOOTBALL NEWS

## “Манчестер Юнайтед” 2016 онд хамгийн олон өмсгөл заржээ

Английн алдарт “Манчестер Юнайтед” клуб өнгөрсөн 2016 онд дэлхий даяар 2.85 сая өмсгөл зарж, борлуулалтаараа тэргүүлжээ. Тэгвэл Испанийн алдарт “Реал Мадрид” клуб 2.29 сая өмсгөл зарж, борлуулалтаараа удаалсан байна. Харин гуравдугаарт “Барселона” клуб 1.98 сая өмсгөл зарсанаараа оржээ. Дөрөвдүгээр байрт Английн “Челси” клуб 1.65 сая өмсгөл зарж орсон бол Германы шилдэг клуб 1.5 саяыг заржээ. Хамгийн их өмсгөл зарсан шилдэг 10 багийн жагсаалтад Английн дөрвөн баг багтсан бол Испани, Италиас хоёр, Герман, Францаас нэг баг багтсан байна. Тэгвэл дэлхий даяар хамгийн их зарагдсан өмсгөл нь “Барселона” клубын довтлогч Мессигийнх юм байна. Харин Роналдо хоёрдугаарт, Погба гуравдугаар байрт бичигджээ. Түүнээс гадна “Манчестер Юнайтед”-ын довтлогч Ибрагимович, хаалгач Де Хеа нарын өмсгөл ч хамгийн их зарагдсан юм байна.

### Хамгийн их өмсгөл зарсан 10 баг

"Манчестер Юнайтед" – 2.85 сая  
"Реал Мадрид" – 2.29  
"Барселона" – 1.98  
"Челси" – 1.65  
"Байерн Мюнхэн" – 1.5  
"Арсенал" – 1.22  
"Ювентус" – 850 мянга  
"Ливерпүүл" – 705  
"ПСЖ" – 685  
"Милан" – 650



## “Боруссия Дортмунд”, “Шальке” шөвгийн наймд үлдлээ



Германы цомын тэмцээний 1/8 шигшээн үлдсэн тоглолтууд өнгөрсөн лхагва гарагийн шөнө боллоо. Энэ шатанд Германы шилдэг баг болох “Боруссия Дортмунд” талбайдаа “Херта” клубыг хүлээж авч, торгуулийн цохилтоор буулгаж авлаа. Ингэснээр шөвгийн наймд шалгарч байгаа юм. Тоглолтын 27 дахь минутад Калу тооны харьцааг нээсэн бол 47 дахь минутад Ройс тэнцүүлжээ. Улмаар торгуулийн цохилт цохиход “Боруссия Дортмунд” 3:2-оор хожжээ. Мөн энэ шатанд “Шальке” клуб “Зандхаузен” клубын талбайд зочилж, 1:4-өөр буулгаж авснаар шөвгийн наймд үлдлээ. Тоглолтын 38 дахь минутад Шопф тооны харьцааг нээж, 43 дахь минутад Калиджури нэгийг нэмсэн бол Налдо 45 дахь минутад нэгийг нэмжээ. Талбайн эзэн багаас 64 дэх минутад Вутен нэр төрийн ганц гоол оруулсан бол Коноплянка 71 дэх минутад гүйцээжээ.

### Шөвгийн наймд үлдсэн багууд

Арминия  
Хамбург  
Боруссия Мюнхенгладбах  
Байерн Мюнхэн  
Шдортфройнд Лотте  
Шальке  
Боруссия Дортмунд  
Айнтрахт

ИХ ДУУЛГА



Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр -8  
Шөнө -21

Нөгөөдөр  
Өдөр -6  
Шөнө -20

Өдрийн зурхай

ӨВЛИЙН АДАГ  
ЦАГААГЧИН ҮХЭР  
САР ЗУРГААН ЦАГААН  
МЭНГЭТЭЙ ШАР ЛҮУ  
ӨДӨР

Наран ургах шингэх: 08.07-18.07

Үс засуулбал: Өлзийтэй сайн



Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, торь жилтнээ аливаа үйлийг хийхэд зөргө сайн ба бар, туулай жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Баяр баясгалангийн хурит үйлдэх, шинэ гэр барих, хувцас өлсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэх, үйл буруутгах, лалд золгох зэрэг цагаан зүйл үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олох, баруун чих хангинавал ундаа олох, зүүн чих хангинавал түлээдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрэв дуугарвал нохойтэй учрах, тагнай загатнавал хувцас олох, бие татвал эгээ, эхэд луу. Хол татвал хэрүүл, тэлцэл гарах луу ёр болой. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

## ПАРИСЫН “ИХ ДУУЛГА” НЯМ ГАРАГТ ЭХЭЛНЭ

Н.БОЛД

Олон улсын жудо бөхийн холбооны календарчилсан төлөвлөгөөнд багтдаг хамгийн нэр хүндтэй, томоохон тэмцээнүүдийн нэг нь Парисын “Их дуулга” билээ. Тэгвэл Францын нийслэлд болдог энэхүү тэмцээн хоёр хоногийн дараа буюу ням гарагт эхлэх гэж байна. Энэ удаагийн Парисын “Их дуулга” тэмцээнд дэлхийн 60 орны эрэгтэй 270, эмэгтэй 161, нийт 431 жудоч өрсөлдөхөөр мэдүүлгээ өгсөн хэмээн Олонулсын жудо бөхийн холбооны албан ёсны сайтад мэдээлсэн байна. Тэгвэл манай улсаас эрэгтэй 10, эмэгтэй есөн жудоч мэдүүлгээ өгсөн хэмээн албан ёсны сайтад мэдээлсэн

байгаа юм. Харин энэхүү бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, зургаан тамирчин хасагдсан байна. Ингэснээр эрэгтэй долоо, эмэгтэй зургаа, нийт 13 жудоч Францыг өнгөрсөн лхагва гарагт зорилоо. Эрэгтэй багийн бүрэлдэхүүнд 60 кг-д Д.Амартүвшин, энэ жилийн улсын аварга Ж.Амарболд, 66-д улсын аварга Г.Хэрлэн, финалдсан Б.Эрхэмбаяр, 73-т Н.Хадбаатар, 81-т Н.Цагвасүрэн, 90-д Г.Алтанбагана нар багтжээ. Харин эмэгтэй багийн бүрэлдэхүүнд 48 кг-д Дэлхийн аварга М.Уранцэцэг, 52-т Л.Сосорбарам, 63-т Б.Мөнгөнчимэг, Б.Ганхайч, +78-д О.Жавзмаа, Э.Гандиймаа нар багтаж, Парисыг зорьсон байна. Энэ удаагийн Парисын

“Их дуулга” тэмцээнд Франц эрэгтэй, эмэгтэй 28 тамирчнаа сойж байна. Харин Гүрж эрэгтэй 13 тамирчнаа л оруулж байгаа юм. Японы багийн хувьд эрэгтэй ес, эмэгтэй 10 тамирчнаа илгээсэн бол Казахстан эрэгтэй таван тамирчин явуулжээ. Ямар ч байсан Францад жүдогийн шилдэг тамирчин чуулах нь. Манай шигшээ багийн хувьд Ж.Амарболд, Л.Алтанбагана, Б.Эрхэмбаяр зэрэг шинэ залуу тамирчдыг илгээсэн. 2020 оны Олимпын циклийн хамгийн эхний том тэмцээн учраас тамирчдын чадвар чансааг шалгах нь тодорхой юм. Энэхүү тэмцээнийг SPS телевиз шууд дамжуулах юм байна. Хэсгийн барилдаанууд Монголын цагаар 00:00 цагт эхэлнэ.

## Дэлхийн цомд өрсөлдөх бөхчүүдийн нэр тодорлоо

Ираны Керманшах хотод чөлөөт бөхийн эрэгтэй багуудын Дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 16-17-нд болно. Тус тэмцээнд манай улсаас 57 кг-ын жинд С.Батболд, 3.Занабазар, 61 кг-д Э.Ням-Очир, Т.Тулга, 65 кг-д Б.Батмагнай нар оролцох юм байна. Харин Гавьяат тамирчин Г.Мандахнаран жин өгсч 70-д, 74 кг-д Б.Анхбаяр, 86 кг-д П.Өнөрбат, 97 кг-д Ө.Батзул, 125 кг-д Н.Золбоо нар өрсөлдөхөөр болжээ. Тэгвэл ДБНХ-ны

ерөнхийлөгч Ненад Лалович тус тэмцээнд оролцох багийг 2015 оны ДАШТ-ий дүнг харгалзан оролцуулахаа мэдэгдлээ. Тухайн жилийн тэмцээнд ОХУ баг түрүүлж, Иран удаалсан тул энэ удаагийн тэмцээний хэсгийг толгойлсон (Монгол Улсын баг дөрөвдүгээр байрт орж байв) байна. Гэхдээ тэр үед наймдугаар байрт орсон Болгарын баг энэ удаагийн тэмцээнд орсонгүй. Тэдний оронд 10 дугаар байрт орсон Энэтхэгийн баг оролцохор

сугалаа татсан байна. Тус тэмцээний шагналын нийт сан 50 мянган ам.доллар бөгөөд түрүүлсэн баг 25, хоёрдугаар байрт шалгарсан баг 15 мянга, гуравдугаар байрт орсон баг 10 мянган ам.долларын шагнал хүртэх юм. Өчигдөр тэмцээний сугалаа татах үйл ажиллагаа болсон бөгөөд манай баг “Б” хэсэгт Иран, Турк, Энэтхэгийн багтай учраа таарсан байна. Харин “А” хэсэгт АНУ, ОХУ, Гүрж, Азербайжаны баг багтжээ.

## Шоу “Тоттенхэм” руу явж магадгүй

Сүүлийн үед гараанд гарч, тоглолтод оролцож чадахгүй байгаа “Манчестер Юнайтед”-ын жигүүрийн хамгаалагч Люк Шоугийн төлөө “Тоттенхэм” санал хүргүүлэхээр төлөвлөж байгаа ажээ. “Тоттенхэм”-ийн дасгалжуулагч Маурисио Почеттино өмнө нь “Саутгэмптон” клубыг дасгалжуулж байхдаа Люк Шоугтай хамтарч ажиллаж байсан удаатай. Улмаар 2014 онд Шоу 27 саяар “Манчестер Юнайтед” руу явж байсан билээ. “Улаан чөтгөрүүд”-ийн дасгалжуулагч Жозе Моуриньо улирлын эхнээс авахуулаад Шоуг барга л

ашиглаагүй. Тэрбээр улирлын 24 тойргийн ердөө долоон удаад нь талбайд гарсан юм. Дээрээс нь бэртэл гэмтэл ч бас нөлөөлж байгаа. Гэхдээ түүний агент Жонатан Барнетт Шоу “Манчестер Юнайтед” клубтэй таарамжгүй харилцаатай болоогүй хэмээн мэдэгдээд байгаа. Ямар ч байсан “Тоттенхэм” түүнийг онилж эхэлж. Улирлын төгсгөлд асуудал илүү тодорхой болох биз ээ.



## ТЭНГИС ХАЙРЫН ШУУДАН

ТЭНГИС  
КИНО ТЕАТР

ХАЙРТАЙ ХҮНДЭЭ ХАМГИЙН САЙХАН СЭТГЭЛИЙН  
ҮГЭЭ ИЛ ЗАХИДЛААР БИЧИЖ ТЭНГИС КИНО ТЕАТР ДОТОР  
БАЙРШИХ ХАЙРЫН ШУУДАНД ХИЙНЭ ҮҮ

3 ХОС ШАЛГАРУУЛЖ 2-Р САРЫН 14-НД

- “FIFTY SHADES DARKER” УСК-ны хос урилга  
- “ДЭЛГЭЦЭЭР МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЭХ” эрхийн бичиг  
- “PREMIUM HOTEL” нэг оройг хамт өнгөрүүлэх эрхийн бичгээр тус тус шагнана.

Захидалдаа холбоо барих утасны дугаараа үлдээнэ үү.

ХАЙРТАЙ ХҮНДЭЭ ХАМГИЙН ГОЁ СЮРПРИЗ БАРИХ БОЛОМЖ

2017.02.08-13 хүртэл  
УТАС: 7000-8070